



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, практик шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.5-д “Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ” гэж, “Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэж, 2.1.4-т “...байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх...” гэж тээврийн салбарын зорилтуудыг тус тус тодорхойлсон.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 5.1-д “Бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрэхийн тулд түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж, 5.2-т “Төмөр замын тээврийн салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг сайжруулна” гэж, 5.3-т “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байж болох бөгөөд өмчийн олон төрөл, хэлбэрийн тээвэрлэгч бий болох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 72-т “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг Засгийн газар санаачлан боловсруулахаар тусгасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, олон улс, бүс нутаг дахь өөрчлөлт, шинэчлэлт болон төмөр замын тээврийн салбарын өнөөгийн нөхцөл байдлаас үүдэн салбарын эрх зүйн орчныг сайжруулах дараахь практик шаардлага байна:

1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, улсын эдийн засаг, нийгмийн нэгдмэл орон зайг бэхжүүлэх зорилгоор төмөр замын сүлжээ байгуулахад баримтлах зарчим, харгалзах хүчин зүйлийг тодорхойлж хуульд тусгах шаардлага үүссэн.

2. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо өсч (2007 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1, тээвэр зуучийн байгууллага 80 орчим байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 3, тээвэрлэгч 3, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 34, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 220, тээвэр зуучийн байгууллага 213 буюу нийт 500 орчим болсон), үйл ажиллагааны төрөл, чиглэл нэмэгдсэн тул эдгээрийн үйл ажиллагаа, хоорондын харилцааг хуулиар зохицуулах шаардлага үүссэн.

3. Төмөр замын бүтээн байгуулалтын явцад үүссэн хөрөнгө оруулалт, зураг төсөл, барилгын ажил, хяналт, зөвлөх үйлчилгээ зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулах шаардлага бий болсон.

4. Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулах, үйлдвэрлэлийг өргөжүүлэх зориулалттай эдэлбэр газар (аюулгүйн бүс, зурвас газар, аюултай бүс)-ыг зориулалтын бусаар эзэмших, ашиглах асуудал гарч байгаа тул хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

5. Төмөр замын тээврийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, төмөр замын байгууллагын эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөх нөхцөлийг боловсронгуй болгох зорилгоор Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу төмөр замын тээврийн салбарын техникийн зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага бий болсон.

6. Хуулиас дээгүүр болзол, шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж, дүрэм, журмаар зохицуулж байгаа тээврийн аюулгүй байдал, дэд бүтэц, эдэлбэр газар, тээвэрлэлт, акт гомдол, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, засвар үйлчилгээ, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгтэй холбоотой харилцааг хуульчлах шаардлагатай.

7. Төмөр замын тээврийн салбарт 16000 орчим ажилтан ажиллагсад, 500 орчим байгууллага, хуулийн этгээд олон төрөл, чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа, шинэ төмөр замуудын бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт эрчимжихийн хэрээр салбарт эрх зүйн зохицуулалт шаардсан харилцаа өргөжиж байна. Тус салбарт төрийн бодлогын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллагын 10 гаруй мэргэжилтний хүрээнд зохицуулан ажиллаж буй нь төмөр замын тээврийн салбар дахь төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг сэргээн байгуулах зүй ёсны шаардлагыг бий болгож байна.

8. Зам, тээврийн хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи хамтран 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчлэлт” салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, Түүнчлэн Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаас “Төмөр замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй” гэсэн зөвлөмжүүд гарсан.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн зорилгыг “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд төмөр замын тээврийн бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох, төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах, хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах, үйлдвэрлэх, тэдгээрийг өмчлөх, эзэмших, ашиглах, нэгдсэн зурмагаар тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой эрх зүй, эдийн засаг, аюулгүй байдал, зохион байгуулалтын харилцааг зохицуулах” гэж тодорхойлох, өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг хамруулахаар хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгана.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэгтэй бөгөөд дараахь агуулгатай байхаар боловсруулна:

- Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, нэр томъёоны тодорхойлолт, төмөр замын тээврийн салбарт баримтлах зарчим, төмөр замын тээврийн норм норматив, техникийн баримт бичиг, норм нормативын сангийн талаарх зохицуулалт;
- Хоёрдугаар бүлэгт төмөр замын тээвэр дэх төрийн зохицуулалт;
- Гуравдугаар бүлэгт төмөр замын тээврийн зориулалтаар ашигладаг эдэлбэр газар, аюулгүй болон хамгаалалтын бүсийн талаар зохицуулалт;
- Дөрөвдүгээр бүлэгт төмөр замын дэд бүтцийн ангилал, өмчлөл, эзэмшил, төмөр замын сүлжээ, дэд бүтцийн ашиглалт үйлчилгээ, төмөр замын өртөө, буудал, терминал, бүтээн байгуулалт болон галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зохицуулалт зэрэгтэй холбоотой зохицуулалт;
- Тавдугаар бүлэгт хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг эзэмших, өмчлөх, угсрах, үйлдвэрлэх, засварлах, арчлах, устгахтай холбоотой зохицуулалт;
- Зургаадугаар бүлэгт төмөр замын тээврийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлттэй холбоотой зохицуулалт буюу тэдгээрийн төрөл, ангилал, нөхцөл, шаардлага, олгох, сунгах, хүчингүй болгох, сэргээхтэй холбоотой зохицуулалт;
- Долоодугаар бүлэгт төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлттэй холбоотой харилцаа, эдгээрийн эрх үүрэг, хариуцлага, акт гомдлыг шийдвэрлэх зэрэг зохицуулалт;
- Наймдугаар бүлэгт төмөр замын тээвэр дэх эдийн засаг, санхүүгийн талаарх зарим зохицуулалт (тарифын бодлого, даатгал гэх мэт);
- Есдүгээр бүлэгт төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зохицуулалт (аюулгүй байдлыг хангах үндэслэл, аюулгүй байдлын тогтолцоо, аюулгүй байдлын шаардлага, төмөр замын тээврийн осол гологдол, шинжлэн шалгах, хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах, онцгой нөхцөлийн үед төмөр замын тээврийг зохион байгуулах, төмөр замын тээврийн дайны байдал шилжүүлэх бэлтгэл, гамшгаас хамгаалах дайчилгаа, тээврийн объектыг хамгаалах, тээвэрт нийтийн хэв журмыг сахиулах, аюултай ачааны тээвэрлэлт гэх мэт);

▪ Аравдугаар бүлэгт төмөр замын тээврийн салбарын ажилтны хөдөлмөрийн харилцааны онцлог зохицуулалт;

▪ Арваннэгдүгээр бүлэгт төмөр замын тээврийн салбарын бусад үйл ажиллагааны талаарх зохицуулалт (төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд анги, эдлэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, сэргээх, засварлах, олон улсын хамтын ажиллагаа, тээвэрт хэрэглэх хэл, цаг, төрийн бус байгууллагын оролцоо гэх мэт).

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлснээр гарах дүн

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Монгол Улсын нийгэм, эдийн засагт дараахь эерэг үр дүн гарна:

1.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний аюулгүйн тогтолцооны эрх зүйн үндсийг хуульчилснаар хүрээлэн буй орчин, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын төвшин, төр, иргэн, хуулийн этгээдийн хариуцлага дээшилж, олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт технологи эзэмших, хөрөнгө оруулалт татах боломж, нөхцөл сайжирна.

2.Төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалт, төмөр замын салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалттай холбоотой үйл ажиллагаа, хөгжлийн орчин нөхцөл сайжирна.

3.Ачаа болон зорчигч тээвэрлэлттэй холбоотой зарим суурь харилцаа хуулийн хүрээнд илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулагдаж төмөр замын сүлжээн дэх хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, өмчийн хэлбэр үл харгалзан төмөр замын тээврийн операторын тэгш оролцоог хангах, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

4.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотой ажилтанд тавигдах шаардлага, ажил, амралтын дэглэм, хөдөлмөрийн сахилга, дэг журам, сургалт, нийгмийн баталгаа зэрэг ажилтантай холбоотой онцлог харилцааны зохицуулалт сайжирна.

5.Төмөр замын тээврийн эдийн засгийн зарим зохицуулалтыг хуульчилснаар төмөр замын тээврийн зах зээлийн төлөөх өрсөлдөөнийг дэмжих, тээврийн бодит өртөгт үндэслэсэн, ашгийн зохих төвшинг хангасан үнэ тарифын уян хатан бодлогыг хэрэгжүүлэх, салбарын аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэн хөгжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

6.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төмөр замын тээврийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсээд байсан зөрчил, давхардал, хийдэл арилна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Газрын тухай, Зөрчлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Эрүүгийн болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Төмөр замын тээврийн тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийг боловсруулна.

---oOo--